Nest Center

# РЕДАКЦ ДАХЬ ХИЙМЭЛ ОЮУНЫ ХЭРЭГЛЭЭ БА ТҮҮНИЙГ ЗОХИЦУУЛАХ НЬ

Л.Анударь, Хөтөлбөр хариуцсан захирал | Сэтгүүл зүйн Инновац Хөгжлийн Үүр төв НҮТББ

2026 оны 09-р сарын 17

Сэтгүүл зүйн ёс зүйн форум, 2026

Nest Center

## Агуулга

- Хэвлэл мэдээллийн байгууллагууд дахь хиймэл оюуны хэрэглээний түвшин
- Монголын хэвлэл мэдээллийн байгууллагууд дахь хиймэл оюуны хэрэглээний түвшин
  - Хиймэл оюуныг хэрэглээнд нэвтрүүлэх айдас ба асуудал, сорилт
  - Хиймэл оюуныг хэрэглээнд нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага ба боломж
- Редакцад хиймэл оюуныг ашиглах журмын төсөл, шийдэгдээгүй асуудлууд...



Nest Center

# Хэвлэл мэдээллийн байгууллагууд дахь хиймэл оюуны хэрэглээний түвшин

**J·Index**

**The Journalism AI Index**

The largest source-linked index of publicly disclosed cases of AI adoption in news media worldwide.

**3,368** verified cases

**2,052** organizations

**141** countries

**2012–2026** years covered

**69%**

*Үйл ажиллагаандаа хиймэл оюун ашиглаж байгаа байгууллагуудын 69% нь хүний хяналтыг чухалчилдаг.*

**35**

*35 байгууллага хиймэл оюуны хэрэглээг бүрэн нутагшуулж чадсан.*

**3026 vs 342**

*Сэтгүүл зүй дэх хиймэл оюуны хэрэглээ туршилтын шатнаас үйлдвэрлэлийн шатанд шилжсэн.*

*Хэвлэл мэдээллийн байгууллагууд дахь хиймэл оюуны хэрэглээ томоохон байгууллагуудад илүү төлөвшсөн байгаа бол жижиг байгууллагууд ихэнхдээ туршилтын шатанд байна.*

# Хэвлэл мэдээллийн байгууллагууд дахь хиймэл оюуны хэрэглээний түвшин

**Хиймэл оюуны нэвтрэлтийн түвшин**

1. *Туршилт, нэвтрэлт*
1. *Үйл ажиллагаанд нутагшуулах*
1. *Мэргэших*
1. *Байгууллагын процесст нэвтрэх*
1. *Байгууллагын процесст дахин инженерчлэл хийж, бизнес загварыг шинэчлэх*



Nest Center

# Хэвлэл мэдээллийн байгууллагууд дахь хиймэл оюуны хэрэглээний түвшин

## Юуг автоматжуулж байна вэ?



Nest Center

# Хэвлэл мэдээллийн байгууллагууд дахь хиймэл оюуны хэрэглээний түвшин



# Хэвлэл мэдээллийн байгууллагууд дахь хиймэл оюуны хэрэглээний түвшин





# Монголын хэвлэл мэдээллийн байгууллагууд дахь хиймэл оюуны хэрэглээний түвшин

Монголын хэвлэл мэдээллийн салбарт хиймэл оюуны хэрэглээ туршилт, үйл ажиллагаанд нутагшиж эхлэх түвшинд байна.

jindex - 5 кэйс бүртгэгдсэн

Thomson Foundation: Ёс зүйн айдас, саарал орон зай нь хиймэл оюуны хэрэглээг хязгаарлаж байна.

FactCheck Mongolia 1
iKon.MN 1
iToim 1
Nest Center 1
TV9 Mongolia 1

Funding: Media dev org (2), Own budget (2), Tech company (Google/GNI) (1)

# Монголын хэвлэл мэдээллийн байгууллагууд дахь хиймэл оюуны хэрэглээний түвшин



Nest Center

# Монголын хэвлэл мэдээллийн байгууллагууд дахь хиймэл оюуны хэрэглээний түвшин

- Хиймэл оюун нь бизнесийн шинэ боломж үүсгэх хэрэглүүр гэхээсээ илүү олон давтагддаг ажлыг хөнгөвчлөх бүтээмж нэмэгдүүлэх хэрэглүүр гэж ойлгодог. Түгээмэл хэрэглээний төрлүүдэд:
  - Судалгаа тоймлох, бичмэл эх сурвалжийн мэдээллийг тоймлох
  - Синтетик видео, постер зэрэг бүтээх
  - Ньюслеттер бичих гм
- Хүний нөөцийн архаг дутагдал, түүнийг нөхөх хэрэгцээ нь хиймэл оюуныг редакцад ашиглах гол хөшүүрэг болж байна.
- Цөөн байгууллага хиймэл оюуныг байгууллагын бизнесийн үйл ажиллагааг сайжруулахад ашиглах сонирхолтой байна.

*Эх сурвалж: Thomson Foundation судалгааны үр дүн*

Nest Center

# Монголын хэвлэл мэдээллийн байгууллагууд дахь хиймэл оюуны хэрэглээний түвшин / Эрсдэл

**80%**

Хиймэл оюунаар үйлдвэрлэсэн хуурамч мэдээлэл сэтгүүл зүйн нэр хүндэд нөлөөлөхөөс гадна, бүрэн нягтлаагүйгээс өөрсдөө хуурамч, ташаа мэдээлэл түгээх эрсдэлтэй

**55%**

Хиймэл оюун хурдтайгаар хөгжиж байгаа тул 2027, 2028 оны сонгуулийн үеэр нягтлах боломжгүй олон хуурамч мэдээллийн давалгаа үүсэх эрсдэлтэй

**85%**

ХМБ-уудын 85% нь ямар нэг журам, зохицуулалтгүйгээр хиймэл оюуныг ялгаатай түвшинд ашигладаг нь цаашид уншигчдын итгэлийг алдах, нэр хүндийн эрсдэлд орох эрсдэлтэй гэж дүгнэв.

**85%**

Редакцууд ашиглах жишиг хиймэл оюун ашиглах ёс зүйн журам, дүрэмтэй болсноор болзошгүй эрсдэлээс сэргийлэх боломжтой

## **Монголын хэвлэл мэдээллийн байгууллагууд дахь хиймэл оюуны хэрэглээний түвшин / Чадавхын зөрүү**




**Хэрэглүүрийн өртөг**

Гадны pro хэрэглүүрүүдийн төлбөр, өртөг өндөр байгаа нь хэрэглүүрийг турших, үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд саад болдог




**Хүний нөөцийн дутагдал**

Хүний нөөц дутагдалтай байгаа нь нэн даруй автоматжуулж болох ажлын байруудыг хиймэл оюунаар нөхөх хэрэгцээг бий болгодог.




**Гадны хэрэглүүрийн чадамж**

Гадны хэрэглүүрүүд монгол хэл дээр тааруу ажилладаг, монгол үндэсний онцлогийг харуулсан дүрслэлийг буруу дүрслэх эрсдэлтэй байдаг нь эргээд тухайн агуулгаа засварлахад илүү их цаг хугацаа зарцуулахад хүргэдэг




**Боловсон хүчний мэдлэг, ур чадвар**

Бусад нөөц бүрдсэн үед ч байгууллагад хиймэл оюуны хэрэглээг нутагшуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулж чадах чадвартай, ойлголттой боловсон хүчин байдаггүй.

Nest Center

# Монголын хэвлэл мэдээллийн байгууллагууд дахь хиймэл оюуны хэрэглээний түвшин

## Боломж

- Хүний нөөцийн дутагдлыг нөхөх
- Дотоод процессийг оновчлох
- Борлуулалтыг дэмжих
- Контентын илэрцийг сайжруулах
- Үзэгчдийн судалгааг сайжруулж, шинэ бизнес загвар нэвтрүүлэх

## Сорилт

- Замбараагүй хэрэглээнээс хамаарч үзэгчдийн итгэлийг алдах
- Нэр хүндийн эрсдэлд орох
- 2027/2028 оны сонгууль
- Зах зээлд ач холбогдолгүй болж, өрсөлдөөнөөс хоцорч үлдэх



*Хиймэл оюуныг борлуулалт, орлого нэмэгдүүлэх гэхээс илүү өртөг бууруулах хэрэгсэл болгон ашиглах хэрэгцээ нэн тэргүүнд байгаа бол олон улсад орлого нэмэгдүүлэх чиглэлээр ашиглах хандлага руу шилжиж байна.*

# Редакцад хиймэл оюун ашиглах журмын төсөл

data.org | Nest Center

**Редакцад хиймэл оюун ухаан ашиглах, зохицуулах бодлого**

Disclaimer:

Энэхүү журам нь Хиймэл оюун ухааныг дараах тодорхойлолтын хүрээнд ойлгож, зохицуулалтыг тодорхойлов.

**Хиймэл оюун ухаан гэж юу вэ?**

*Хиймэл оюун ухаан гэдэг нь хүний оюунаар бүтээдэг өгөгдөлд суурилсан аливаа даалгаврыг тооцооллын аргаар боловсруулах хүний бүтээсэн технологи юм. Энэхүү технологи нь их хэмжээний өгөгдөлд суурилан дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах, урт хугацааны түүхийн өгөгдөлд суурилан ирээдүйн тооцоолол хийх, шийдвэр гаргах зэрэг үйлдлийг хийнэ.*

*Generative AI гэдэг нь өгөгдсөн өгөгдөлд суурилан текст, зураг, аудио, дуу хоолой, дуу хөгжим, видео болон код бүтээх чадвартай хиймэл оюуны нэг төрөл юм.*

Энэхүү тодорхойлолтын хүрээнд хиймэл оюун ухаан нь тухайн ашиглаж байгаа моделийн алгоритм, алгоритмыг сургасан өгөгдлөөс хамаарсан тодорхой хэмжээний хэвшмэл ойлголтыг агуулсан, өгөгдөл, төлөвт тулгуурлан төөрөгдөх сул талтай технологи бөгөөд, ямар нэг супер технологи биш гэдгийг хүлээн зөвшөөрч, түүний сул талаас хамааран сэтгүүл зүйн өдөр тутмын үйл ажиллагаанд учирч болох аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү журмыг ашиглана.

Редакцад хиймэл оюун ухаан ашиглах, зохицуулах бодлого:

- Үндсэн 13 бүлэгтэй
- Үүнээс ерөнхий буюу нийтлэг зохицуулалт 10 бүлэг
- Хэвлэл мэдээллийн байгууллагад түгээмэл хэрэгждэг 3 төрлийн үйл ажиллагаагаар хуваарилсан үндсэн практик хэрэглээ зохицуулах 3 бүлэг
  - Текст агуулга, судалгаанд хиймэл оюун ухаан ашиглах бодлого ба хязгаарлалт
  - Видео, аудио болон зурган агуулгад хиймэл оюун ухаан ашиглах бодлого ба хязгаарлалт
  - Байгууллагын бүтээмж, үйл ажиллагааг оновчлоход хиймэл оюун ухаан ашиглах бодлого ба хязгаарлалт

Nest Center

# Редакцад хиймэл оюун ашиглах журмын төсөл

**Редакцад хиймэл оюун ухаан ашиглах, зохицуулах бодлого**

Disclaimer:

Энэхүү журам нь Хиймэл оюун ухааныг дараах тодорхойлолтын хүрээнд ойлгож, зохицуулалтыг тодорхойлов.

**Хиймэл оюун ухаан гэж юу вэ?**

*Хиймэл оюун ухаан гэдэг нь хүний оюунаар бүтээдэг өгөгдөлд суурилсан аливаа даалгаврыг тооцооллын аргаар боловсруулах хүний бүтээсэн технологи юм. Энэхүү технологи нь их хэмжээний өгөгдөлд суурилан дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах, урт хугацааны түүхийн өгөгдөлд суурилан ирээдүйн тооцоолол хийх, шийдвэр гаргах зэрэг үйлдлийг хийнэ.*

*Generative AI гэдэг нь өгөгдсөн өгөгдөлд суурилан текст, зураг, аудио, дуу хоолой, дуу хөгжим, видео болон код бүтээх чадвартай хиймэл оюуны нэг төрөл юм.*

Энэхүү тодорхойлолтын хүрээнд хиймэл оюун ухаан нь тухайн ашиглаж байгаа моделийн алгоритм, алгоритмыг сургасан өгөгдлөөс хамаарсан тодорхой хэмжээний хэвшмэл ойлголтыг агуулсан, өгөгдөл, төлөвт тулгуурлан төөрөгдөх сул талтай технологи бөгөөд, ямар нэг супер технологи биш гэдгийг хүлээн зөвшөөрч, хүний сул талаас хамааран сэтгүүл зүйн өдөр тутмын үйл ажиллагаанд учирч болох аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү журмыг ашиглана.

data.org

International Federation of Journalists

FINANCIAL TIMES

AP

BBC

Archival Producers Alliance

# Редакцад хиймэл оюун ашиглах журмын төсөл

**Болзошгүй эрсдэлээс сэргийлэх үндсэн 11 зарчмыг баримталж ажиллана:**

1. Редакц нь хиймэл оюуныг зардал бууруулах, хүний нөөцийг танах зорилгоор бус орлогоо өсгөх, бүтээмжээ нэмэгдүүлэх, сэтгүүл зүйн бүтээлийн чанарыг сайжруулах, хэрэглэгчдэдээ илүү ойртох зорилгоор ашиглана.
2. Хариуцлагатай хэрэглээ
3. Гарцаагүй хэрэглээ
4. Баримтад суурилсан байдал
5. Оюуны өмчийг дээдлэх
6. Ил тод байдал

1. Хүний эрхийг дээдлэх
2. Хувийн нууц ба мэдээллийн аюулгүй байдал
3. Синтетик контент бодит контенттой үл өрсөлдөх зарчим
4. Хэмнэгдсэн цаг хугацааг утга учиртай ажилд зарцуулах
5. Хүн хоорондын биет харилцааг эрхэмлэх

## STEPPE FORWARD:
## Хиймэл оюунд тэсвэртэй мэдээллийн эдийн засгийг бүтээх нь

# ACTIVATE AI CHALLENGE

| | | |
|---|---|---|
| Редакцад хиймэл оюун ашиглах журам | 30 жилийн сонины архивыг ашиглан хиймэл оюун таних боломжтой монгол хэл дээрх дата сан үүсгэх | Хиймэл оюун зохистой ашиглах чадавх бүхий хүний нөөц бэлдэх сургалт |

# STEPPE FORWARD: Монгол хэл дээрх хиймэл оюуны ирээдүйг найдвартай өгөгдлөөс бүтээх нь

Эндээс бүтнээр уншиж танилцана уу.

Хиймэл оюуныг ёс зүйтэй ашиглах нь сэтгүүлчдэд зориулсан сургалтад бүртгүүлээрэй.

Nest Center

# БАЯРЛАЛАА